

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Ахмадын чөлөөт холбооны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: **ӨМА-2022/63/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.umnugovi@audit.gov.mn Өмнөговь аймаг 2022 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр Утас: 70533539 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 88034203 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Аудитор: Э.Жаргал Утас: 88025452 Цахим хаяг: jargale@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН АХМАДЫН
ЧӨЛӨӨТ ХОЛБООНЫ ТЭРГҮҮН
Ц.ЭНХЧИМЭГ ТАНАА

2022.02.23 № 156
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Ахмадын чөлөөт холбооны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Өмнөговь аймгийн Ахмадын чөлөөт холбооны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бэлэн мөнгө болон худалдан авсан 20,067,092 төгрөгийн бараа материалын зарцуулалтын тайлан гаргаагүй, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг баримтыг байгууллагын дарга баталгаажуулаагүй зөрчил нь, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын 2016 оны 347 дугаар тушаал, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт, толилуулга, эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

010002057

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A handwritten signature in black ink, appearing to read 'С.Цэрэнбаяр', is written over a faint red rectangular stamp. The signature is fluid and stylized.

С.ЦЭРЭНБАЯР

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	20.0	7.9
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	-	12.0
	Нийт хөрөнгийн дүн	20.0	19.9
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	20.0	19.7
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	20.0	19.9
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	-	115.7
	Үйл ажиллагааны зардлын дүн	-	96.1
	Үйл ажиллагааны үр дүн		19.7
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	-	19.7
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	20.0
	Тайлант оны үр дүн	-	19.7
	Эцсийн үлдэгдэл	-	19.7
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	-	116.7
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	-	103.7
	Үйл ажиллагааны ЦМГ	-	13.0
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	2.4
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2.4

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өмнөговь аймгийн Ахмадын чөлөөт холбоо нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо "Ахмад настны тухай хуульд заасан зорилго, зорилт чигт үүргийг сахихаас гадна, ахмад буурлуудынхаа сайн сайхны төлөө хууль ёсны нийтлэг эрх ашиг, эв нэгдлийг хангаж, аль ч намын үзэл сурталд үл автан, хуулиа дээдлэн ажиллах" гэж тодорхойлон, "Мөн ахмад настанд үзүүлэх нийгмийн хамгааллын үйлчилгээний төрөл хэмжээг тогтоож, төрийн болон ААНБ-ын хүлээх эрх үүргийг тодорхойлоход холбогдох харилцааг зохицуулах" зорилтыг тавин ажилладаг байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Маягт заавар батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- **Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал буюу Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Маягт заавар батлах тухай”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

- Цагийн бүртгэлийг Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал " Маягт заавар батлах тухай"-г хөтлөөгүй,
- Бэлнээр 10,8 сая төгрөг зарцуулахдаа бэлэн мөнгөний зарцуулалтын тайлан гаргаагүй,
- худалдан авсан бараа материал 9,7 сая төгрөгийн тайланг гаргаагүй байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Өмнөговь аймгийн Ахмадын чөлөөт холбоо нь Нягтлан бодох бүртгэлийг программаар бүртгээгүй, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг байгууллагын дарга баталгаажуулаагүй байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн бөгөөд нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгаж тусгасан болно.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шалгагдагч байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Маягт заавар батлах тухай”-ыг мөрдөж ажиллаагүй байна. Иймд дараагийн аудитаар горим сорил хэрэгжүүлэн анхаарч үзэх шаардлагатай гэж үзэв.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 289,3 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 269,3 сая төгрөгийн алдааг залруулж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал "Маягт заавар батлах тухай", Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ын хэрэгжилттэй 6 зөвлөмж өгсөн.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг байгууллагын дарга баталгаажуулаагүй байна.

Өгсөн Зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 18.2 "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль

тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" заалтыг хэрэгжүүлэн ажиллах,

2.Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийг программаар бүртгээгүй байна.

Өгсөн Зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.11 "Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программ хангамжийг нийтэд мэдээлэх" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах,

3.Илрүүлэлт:

Бэлнээр 10,8 сая төгрөг зарцуулахдаа бэлэн мөнгөний зарцуулалтын тайлан гаргаагүй байна.

Өгсөн Зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах", Сангийн сайдын 2016 оны 347 дугаар тушаал "Маягт заавар батлах тухай"-г хэрэгжүүлэн ажиллах,

4.Илрүүлэлт:

Цагийн бүртгэлийг Сангийн сайдын 2016 оны 347 дугаар тушаал " Маягт заавар батлах тухай"-г хөтлөөгүй байна,

Өгсөн Зөвлөмж:

Сангийн сайдын 2016 оны 347 дугаар тушаал "Маягт заавар батлах тухай"-г хэрэгжүүлж хэвших

5.Илрүүлэлт:

Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт " Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл"-д хамааруулан ажилчдын цалинг Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор цалинжуулсан байна.

Өгсөн Зөвлөмж:

Төрийн бус байгууллагад ажиллаж байгаа ажилчдын цалинг Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулан ажиллах,

6.Илрүүлэлт:

Тус онд худалдан авсан бараа материал 9,3 сая төгрөгийн тайланг гаргаагүй байна.

Өгсөн Зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 "Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөний газар нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана", 20 дугаар зүйлийн 20.1.1 "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах" гэсэн заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах,

Аудитаар өгөгдсөн албан шаардлагын хэрэгжилтийг 2022 оны 5 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ТШЗ	9	289,3	3	269,3	0	0	0	0	6	20,0
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн	9	289,3	3	269,3	0	0	0	0	6	20,0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	ТШЗ	0	0	0	0	0	0	2	0	0	0
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн	0	0	0	0	0	0	0	0	0	0
	НИЙТ ДҮН	9	289,3	3	269,3	0	0	0	0	6	20,0